



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/2144

Хэрлэн сум

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд Хэнтий аймгийн баг тамирчдыг оролцуулсугай.

2. Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд Хэнтий аймгийн баг тамирчдыг оролцуулахыг Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Солонго)-д үүрэг болгосугай.

3. Дээрх тэмцээнд шаардагдах 50,000,000 (тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

